



АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨМЖ

Цахим орчинд иргэдийн санхүүгийн мэдээлэл болон банкны дансанд халдах, дансанд дахь мөнгийг зөвшөөрөлгүй гуйвуулах, залилан хийх гэмт хэргүүд идэвхжиж байгаатай холбогдуулан Чингис Хаан Банкны зүгээс харилцагч танд доорх зөвлөмжийг хүргүүлж байна.

1. ЕРӨНХИЙ


- ✚ Интернэт банкаа хэрэглэж дуусах бүртээ гарах товчыг даран холболтоо салгаж байх;
- ✚ Олон нийтийн газар интернэт банк руугаа нэвтрээд нээлттэй үлдээхгүй байх;
- ✚ Олон нийтийн газар нийтийн wi-fi ашиглаж интернэт банк руугаа нэвтрэх нь хувийн мэдээлэл, нууц үгээ алдах эрсдэлийг бий болгодог тул зөвхөн найдвартай сүлжээ ашиглах;
- ✚ Өөрийн нэвтрэх нэр нууц үг зэрэг мэдээллийг цаасан дээр тэмдэглэх, файлаар хадгалах нь эрсдэлтэй.

2. НУУЦ ҮГТЭЙ ХОЛБООТОЙ

- ✚ Өөрийн хувийн мэдээлэл, нэр, регистрийн дугаар, утасны дугаар зэргийг нууц үгээрээ сонгох нь мэдээллээ алдах эрдсэл үүсгэнэ;
- ✚ Өөрийн мэйл болон фэйсбүүк, олон нийтийн сүлжээнд ашигладаг нууц үгээр интернэт банкиндаа давхар ашиглах эсвэл аль нэг нууц үгээ алдахад санхүүгийн мэдээлэл, хөрөнгөө алдах эрсдэлийг нэмэгдүүлдэг.


3. ХУУРАМЧ PHISHING САЙТ, МЭЙЛТЭЙ ХОЛБООТОЙ

- ✚ Чингис Хаан Банкны интернэт банк руу хандахдаа URL хаяг дээрх бүх үгс зөв байгаа эсэх, хаягийн урд талд байх сертификатын зураг ногоон өнгөтэй хэвийн байгааг доорх линктэй тулгаж, шалгаж үзэх.



← Чингис Хаан Банкны интернет банкны URL хаяг

- ✚ Интернэт банкны нэр, нууц үг, болон бусад мэдээллээ өгөх тухай, хувийн мэдээлэл шаардсан, сэжигтэй гарчиг, линк бүхий мэйл нээж үзэхгүй, хариу бичихгүй, дээр нь дарахгүй байх. Доорх зургаас харна уу!



Зураг-1 /Хуурамч и-мэйл жишээ/